



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АХМАД НАСТНЫ ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/23/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот  
2022 он

Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх  
аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Б.Сэржмядаг  
Утас: 261628 Цахим хаяг: [serjmyadagb@audit.gov.mn](mailto:serjmyadagb@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Б.Нарангэрэл  
Утас: 261628 Цахим хаяг: [narangerel@audit.gov.mn](mailto:narangerel@audit.gov.mn)  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Бэст фортуна аудит ХХК  
Захирал: Ж.Оюунцэцэг  
Утас: 324338, 89116465, 98056465  
Цахим хаяг: [fortune2009audit@gmail.com](mailto:fortune2009audit@gmail.com)

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6-7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9-10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11-12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл .....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
3.4 Материаллаг байдал .....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15-16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал .....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	17
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
4. Аудитын илрүүлэлт .....	18
4.1 Залруулсан алдаа .....	18-19
4.2 Төлбөрийн акт .....	19
4.3 Албан шаардлага .....	19-20
4.4 Зөвлөмж.....	20-21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	24
Төлбар барагдуулах тухай .....	25
Зөрчил арилгах тухай .....	26-29

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХНХЯ	Хөдөлмөр нийгэм хамгааллын яам
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ТБОНӨХБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2022.02.24 № 07/342  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

АХМАД НАСТНЫ ҮНДЭСНИЙ  
ТӨВИЙН ДАРГА Л.ЭРДЭНЭХҮҮ  
ТАНАА

**Аудитын санал дүгнэлт**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ахмад настны үндэсний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ахмад настны үндэсний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

\\10.10.10.20\Bichig\_Khareg\Yawsan\_Bichig\2022\0225 Auditin 2 Gazar -3.Docx

001050306

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>758,083,557.36</u></b>	<b><u>502,893,743.27</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>		-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	49,766,322.00	44,267,429.18
33300	Татаас, санхүүжилтийн авлага	6,550,922.00	1,052,029.18
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	43,215,400.00	43,215,400.00
3351	Байгууллагаас авах авлага	43,215,400.00	43,215,400.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	708,317,235.36	458,626,314.09
351	Түүхий эд материал	41,692,235.46	23,321,618.09
35130	Эм боох материал	41,692,235.46	23,321,618.09
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	573,214,999.90	355,434,696.00
35410	Бичиг хэргийн материал	995,500.00	1,842,500.00
35420	Аж ахуйн материал	263,094,258.00	266,432,887.99
35440	Түлш шатах тослох материал	6,000,000.00	5,400,000.00
35430	Хүнсний материал	239,446,641.90	19,228,308.01
35470	Бусад хангамжийн материал	63,678,600.00	62,531,000.00
35600	Мал амьтад	93,410,000.00	79,870,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>10,799,117,830.45</u></b>	<b><u>10,533,165,324.31</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	10,799,117,830.45	10,533,165,324.31
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	10,404,275,230.45	10,138,322,724.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	10,391,693,398.08	10,391,693,398.08
39202	Хуримтлагдсан элэгдэл	(874,646,254.52)	(1,068,009,694.59)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	242,598,764.00	243,118,764.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(209,378,509.28)	(210,257,886.60)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,214,276,868.44	1,256,857,108.44
39206	Хуримтлагдсан элэгдэл	(420,535,318.45)	(548,543,434.63)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	149,044,580.00	156,104,580.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(88,778,297.82)	(97,612,110.39)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	-	14,972,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	394,842,600.00	394,842,600.00
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(770,000.00)	(770,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	394,842,600.00	394,842,600.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>11,557,201,387.81</u></b>	<b><u>11,036,059,067.58</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>11,557,201,387.81</u></b>	<b><u>11,036,059,067.58</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	11,557,201,387.81	11,036,059,067.58
511	Засгийн газрын оруулсан капитал	1,264,908,232.00	1,264,908,232.00
51101	Өмч: - төрийн	1,264,908,232.00	1,264,908,232.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	9,487,367,316.77	8,966,224,996.54
51210	Өмнөх үеийн үр дүн	9,909,885,915.91	9,487,367,316.77
51220	Тайлант үеийн үр дүн	(422,518,599.14)	(521,142,320.23)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	804,925,839.04	804,925,839.04
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>11,557,201,387.81</u></b>	<b><u>11,036,059,067.58</u></b>



## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,944,439,755.68</b>	<b>2,705,111,477.18</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>665,244,055.68</b>	<b>326,439,177.18</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	665,244,055.68	326,439,177.18
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	593,354,775.00	198,831,456.18
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	180,273,275.00	175,487,456.18
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	413,081,500.00	23,344,000.00
120009	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө	12,346,881.68	63,440,240.00
	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Бараа материал	59,542,399.00	64,167,481.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,279,195,700.00</b>	<b>2,378,672,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,279,195,700.00	2,378,672,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,279,195,700.00	2,378,672,300.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,366,958,354.82</b>	<b>3,226,253,797.41</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,366,958,354.82</b>	<b>3,226,253,797.41</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	3,278,181,353.72	3,095,117,037.89
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,209,343,773.29	1,171,241,541.54
210101	Үндсэн цалин	818,254,172.24	773,657,666.89
210102	Нэмэгдэл	337,901,980.05	340,509,708.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	53,187,621.00	57,074,166.65
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	150,217,243.40	157,280,431.94
210201	Тэтгэврийн даатгал	106,751,792.44	111,785,348.20
210202	Тэтгэмжийн даатгал	12,109,473.22	11,993,857.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,590,137.93	9,453,963.12
210204	Ажилгүйдлийн даатгал	2,294,352.59	2,179,010.67
210205	Эрүүл мэндийн даатгал	19,471,487.22	21,868,252.74
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	288,677,204.00	289,700,191.00
210301	Гэрэл, цахилгаан	115,365,354.00	118,560,191.00
210302	Түлш, халаалт	165,600,000.00	167,840,000.00
210303	Цэвэр, бохир ус	7,711,850.00	3,300,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	153,310,303.01	117,382,202.01
210401	Бичиг хэрэг	3,575,250.00	2,669,100.00
210402	Тээвэр, шатахуун	43,570,950.00	34,044,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,427,190.00	4,153,150.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,295,800.00	9,713,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	96,441,113.01	55,129,152.01
	Бараа материал шилжүүлсэний зардал		11,672,000.00
<b>2106</b>	<b>Норматив зардал</b>	910,348,648.54	861,380,145.26
210601	Эм	125,778,046.44	153,461,232.37
210604	Хоол	609,596,349.23	582,765,083.89
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	174,974,252.87	125,153,829.00
	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	119,440,671.67	62,535,700.00
210604	Урсгал засвар	119,440,671.67	62,535,700.00

**Ахмад настны үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	464,000.00	240,000.00
210702	Дотоод албан томилолт	464,000.00	240,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	51,636,098.00	50,632,080.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	42,499,746.00	37,875,264.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,500,000.00	11,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	611,940.00	311,550.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	446,328.00	559,420.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		199,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	1,844,570.00	588,500.00
210807	Газрын төлбөр	733,514.00	98,346.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	394,743,411.81	384,724,746.14
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,870,000.00	43,660,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	360,873,411.81	341,064,746.14
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	88,777,001.10	131,136,759.52
213202	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,200,000.00	44,585,200.00
213204	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	1,200,000.00	2,450,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	42,135,200.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	87,577,001.10	86,551,559.52
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	87,577,001.10	86,551,559.52
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(422,518,599.14)</b>	<b>(521,142,320.23)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(422,518,599.14)</b>	<b>(521,142,320.23)</b>



## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,264,908,232.00	804,925,839.04	9,909,885,915.91	11,979,719,986.95
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,264,908,232.00	804,925,839.04	9,909,885,915.91	11,979,719,986.95
C07	Тайлант үеийн үр дүн			(422,518,599.14)	(422,518,599.14)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,264,908,232.00	804,925,839.04	9,487,367,316.77	11,557,201,387.81
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,264,908,232.00	804,925,839.04	9,487,367,316.77	11,557,201,387.81
D08	Тайлант үеийн үр дүн			(521,142,320.23)	(521,142,320.23)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,264,908,232.00	804,925,839.04	8,966,224,996.54	11,036,059,067.58

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>2,887,740,369.00</u></b>	<b><u>2,572,382,678.18</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>593,354,775.00</b>	<b>187,159,456.18</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	593,354,775.00	187,159,456.18
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	593,354,775.00	187,159,456.18
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	180,273,275.00	175,487,456.18
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	413,081,500.00	11,672,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,294,385,594.00</b>	<b>2,385,223,222.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,279,195,700.00	2,378,672,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,279,195,700.00	2,378,672,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	15,189,894.00	6,550,922.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,189,894.00	6,550,922.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>2,878,951,029.00</u></b>	<b><u>2,560,710,678.18</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,878,951,029.00</b>	<b>2,560,710,678.18</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,783,623,105.90</b>	<b>2,428,521,889.48</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,208,058,727.50	1,169,009,128.54
210101	Үндсэн цалин	816,969,126.45	782,460,259.89
210102	Нэмэгдэл	337,901,980.05	332,508,297.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	53,187,621.00	54,040,571.65
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	150,217,243.40	159,512,844.94
210201	Тэтгэврийн даатгал	103,279,758.44	115,170,909.92
210202	Тэтгэмжийн даатгал	12,109,473.22	11,263,348.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,590,137.93	8,963,099.21
210204	Ажилгүйдлийн даатгал	2,294,352.59	2,187,436.95
210205	Эрүүл мэндийн даатгал	22,943,521.22	21,928,050.04
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	300,166,354.00	301,520,191.00
210301	Гэрэл, цахилгаан	115,365,354.00	118,560,191.00
210302	Түлш, халаалт	165,600,000.00	167,840,000.00
210303	Цэвэр, бохир ус	19,201,000.00	15,120,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	137,567,842.00	74,283,960.00
210401	Бичиг хэрэг	2,459,300.00	2,030,700.00
210402	Тээвэр, шатахуун	40,802,800.00	21,624,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,427,190.00	4,153,150.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	29,459,600.00	9,713,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	62,418,952.00	36,761,310.00
	<b>Норматив зардал</b>	793,793,000.00	526,115,000.00
210501	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	67,545,300.00	59,012,400.00
210502	Хоол, хүнс	597,072,700.00	355,150,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	129,175,000.00	111,952,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,490,680.00	4,097,600.00
210604	Урсгал засвар	2,490,680.00	4,097,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	464,000.00	240,000.00
210702	Дотоод албан томилолт	464,000.00	240,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	190,865,259.00	193,743,165.00

Ахмад настны үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	180,943,807.00	180,986,349.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,500,000.00	11,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	611,940.00	311,550.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	446,328.00	559,420.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		199,000.00
210807	Газрын төлбөр	733,514.00	98,346.00
210808	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,844,570.00	588,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>95,327,923.10</b>	<b>132,188,788.70</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,200,000.00</b>	<b>44,585,200.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	42,135,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	2,450,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	94,127,923.10	87,603,588.70
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>8,789,340.00</u></b>	<b><u>11,672,000.00</u></b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	-	-
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>9,574,440.00</b>	<b>11,672,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>9,574,440.00</b>	<b>11,672,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	9,574,440.00	11,672,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,574,440.00	11,672,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>(9,574,440.00)</u></b>	<b><u>(11,672,000.00)</u></b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-785,100.00</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>785,100.00</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,101,917,300.00</b>	<b>2,466,556,167.48</b>	<b>628,810,110.52</b>	79.5
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	3,101,917,300.00	2,473,107,089.48	628,810,110.52	79.7
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	3,057,274,400.00	2,428,521,889.48	628,752,510.52	79.4
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,511,823,800.00	1,169,009,128.54	342,814,671.46	77.3
210101	Үндсэн цалин	1,113,026,500.00	782,460,259.89	330,566,240.11	70.3
210102	Нэмэгдэл	348,541,000.00	332,508,297.00	16,032,703.00	95.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	50,256,300.00	54,040,571.65	(3,784,271.65)	107.5
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	203,134,200.00	159,512,844.94	43,621,355.06	78.5
210201	Тэтгэврийн даатгал	144,050,300.00	115,170,909.92	28,879,390.08	80.0
210202	Тэтгэмжийн даатгал	14,731,600.00	11,263,348.82	3,468,251.18	76.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,655,000.00	8,963,099.21	2,691,900.79	76.9
210204	Ажилгүйдлийн даатгал	3,309,400.00	2,187,436.95	1,121,963.05	66.1
210205	Эрүүл мэндийн даатгал	29,387,900.00	21,928,050.04	7,459,849.96	74.6
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	330,540,300.00	301,520,191.00	29,020,109.00	91.2
210301	Гэрэл, цахилгаан	138,294,000.00	118,560,191.00	19,733,809.00	85.7
210302	Түлш, халаалт	173,828,800.00	167,840,000.00	5,988,800.00	96.6
210303	Цэвэр, бохир ус	18,417,500.00	15,120,000.00	3,297,500.00	82.1
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	79,442,400.00	74,283,960.00	5,158,440.00	93.5
210401	Бичиг хэрэг	2,039,300.00	2,030,700.00	8,600.00	99.6
210402	Тээвэр, шатахуун	25,181,500.00	21,624,900.00	3,556,600.00	85.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,199,600.00	4,153,150.00	46,450.00	98.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,212,000.00	9,713,900.00	1,498,100.00	86.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	36,810,000.00	36,761,310.00	48,690.00	99.9
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	740,541,500.00	526,115,000.00	214,426,500.00	71.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	59,016,000.00	59,012,400.00	3,600.00	100.0
210502	Хоол, хүнс	569,554,300.00	355,150,000.00	214,404,300.00	62.4
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	111,971,200.00	111,952,600.00	18,600.00	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,097,600.00	4,097,600.00	0	100.0
210604	Урсгал засвар	4,097,600.00	4,097,600.00	0	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	253,500.00	240,000.00	13,500.00	94.7
210702	Дотоод албан томилолт	253,500.00	240,000.00	13,500.00	94.7
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	187,210,700.00	193,743,165.00	(6,532,465.00)	103.5

Ахмад настны үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан					
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	174,447,700.00	174,735,427.00	(6,538,649.00)	100.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	11,000,000.00	11,000,000.00	0	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	311,600.00	311,550.00	50	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	559,500.00	559,420.00	80	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	200,000.00	199,000.00	1,000.00	99.5
210808	Мэдээллийн технологийн татвар	593,500.00	588,500.00	5,000.00	99.2
210809	Газрын төлбөр	98,400.00	98,346.00	54	99.9
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	230,400.00	0	230,400.00	0.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	230,400.00	0	230,400.00	0.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	44,642,800.00	44,585,200.00	57,600.00	99.9
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	44,642,800.00	44,585,200.00	57,600.00	99.9
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,135,200.00	42,135,200.00	0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,507,600.00	2,450,000.00	57,600.00	97.7
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,101,917,300.00</b>	<b>2,466,556,167.48</b>	<b>635,361,132.52</b>	<b>79.5</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	2,378,672,300.00	2,291,068,711.30	87,603,588.80	96.3
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,378,672,300.00	2,291,068,711.30	87,603,588.80	96.3
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	723,245,000.00	175,487,456.18	541,206,621.82	24.3
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	174,447,700.00	175,487,456.18	(1,039,756.18)	100.6
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	548,797,300.00		548,797,300.00	0.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих		0	0	
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		0	0	
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		0	0	
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		0	0	
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	-	0	0	
610001	Төсвийн байгууллага		0	0	
610002	Төсвөөс гадуур байгууллага		0	0	
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	127	111	16	87.4
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	42	32	10	76.2
	Үйлчлэх ажилтан	80	74	6	92.5
620019	Гэрээт ажилтан	4	4	0	100.0
650010	Гэрээт ажилтан				
650011	Улс төрийн албан хаагч				

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ахмад настны үндэсний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад хөрөнгийн хөдөлгөөнийг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаж байх тухай, холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно

Аудитыг 2021 оны 11 дүгээр сарын 15-наас 2020 оны 2 дугаар сарын 15-ны хооронд Бэст фортуна аудит ХХК-ийн аудитор Н.Эрдэнэбат, аудитор Ч.Дуламсүрэн нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Ж.Оюунцэцэг хэрэгжүүлсэн.

Ахмад настны үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Бэст фортуна аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 13 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ахмад настны үндэсний төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь үйлчлүүлэгчийн эрхийг хүндлэн дээдэлж, сэргээн засах эмчилгээ сувилгаа үзүүлэх, тодорхой хөтөлбөрүүдэд хамруулан чадавхжуулах, хөгжүүлэх, цаашид удаан амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, амьдрах ухааны дадал чадвар эзэмшүүлэх, нийгэмшүүлэх, аюулгүй орчноор хангахад оршино.

Ахмад настны үндэсний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Ахмад настныг тэжээн тэтгэх хүүхэдгүй, бие даан амьдрах чадваргүй ганц бие, эсхүл тэжээн тэтгэх хүүхэд нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэйн улмаас дэмжлэг тусалцаа үзүүлэх чадваргүй, тэжээн тэтгэх үүрэгтэй этгээд нь тухайн ахмад настны эсрэг хүчирхийлэл үйлдсэн болох нь тогтоогдсон бөгөөд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах боломжгүй ахмад настнуудад:

- Үйлчлүүлэгчийг зориулалтын байранд эрүүл аюулгүй, таатай орчинд амьдруулах,
- Үйлчлүүлэгчдэд эрүүл ахуйн шаардлага хангасан хоол, хувцас, эм тариа, ахуйн хэрэгслээр хангах
- Үйлчлүүлэгч бүрийн нөхцөл байдлын үнэлгээ хийж, тэдний хөгжил, хамгааллын шаардлагатай бүх үйлчилгээг үзүүлэх, амьдралын хэвийн нөхцлийг бүрдүүлэх, хууль тогтоомжид заасны дагуу хамгаалах.
- Үйлчлүүлэгч бүрд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ асаргаа сувилгааг үзүүлэх үйлчилгээ нь хүнд сурталгүй, авилгаас ангид, ашиг сонирхлын зөрчилгүй байх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;

- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод хяналтын хариуцсан ажилтан нь санхүү бүртгэлийн мэргэжилгүй тул хөрөнгө, санхүү, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой хяналт хангалтгүй гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй, өмнөх оны аудитаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрийн үйл ажиллагааны онцлогийг тусган боловсруулж мөрдөж зөвлөмж өгсөн боловч хэрэгжээгүй байна.

Дотоод хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн тайлант онд 6 чиглэлээр, 13 арга хэмжээний хүрээнд 41 ажил хийхээр төлөвлөж, гүйцэтгэлийг тайлагнасан боловч хяналт шалгалт хийх удирдамж, өгсөн зөвлөмж байхгүй, хийсэн ажил нь тодорхой бус, үр дүнг хангалтгүй гэж үзлээ.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналтын ажилтны гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ахмад настны үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр бэлтгэж ирүүлсэн боловч доорх зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Нэмэлт санхүүжилт, түүний зарцуулалтыг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэн гаргасан;
- Төсвийн гүйцэтгэл, нэмэлт санхүүжилтийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийг цэвэрлээгүй тайлагнасан;
- Туслах аж ахуйн орлогыг төрийн сангийн харилцах дансанд төвлөрүүлж холбогдох зардлын зүйл ангид зардал хуваарилуулаагүй, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар тайлагнаагүй байна.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 2,878,165.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 28,781.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.



### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Ахмад настны үндэсний төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 521,142.3 мянган төгрөгөөр буюу 5,1 хувиар буурч материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	49,766.3	44,267.4	(5,498.9)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	708,317.2	458,626.4	(249,690.8)
Үндсэн хөрөнгө	10,799,117.9	10,533,165.3	(265,952.6)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>11,557,201.4</b>	<b>11,036,059.1</b>	<b>(521,142.3)</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	11,557,201.4	11,036,059.1	(521,142.3)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>11,557,201.4</b>	<b>11,036,059.1</b>	<b>(521,142.3)</b>

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлага данс өмнөх онд буцаан төвлөрүүлж авлагаар тайлагнасан санхүүжилтийн авлага төлөгдсөнөөс шалтгаалж 5,498.9 мянган төгрөгөөр буурсан.
- Бараа материалын данс эм, эмнэлэгийн хэрэгсэл болон хүнсний материалын чанар байдал, хадгалах хугацаанаас хамаарч үлдэгдлийн нөөцийг бага хэмжээгээр бүрдүүлж байгаагаас шалтгаалж 249,690.8 мянган төгрөгөөр буурсан.
- Үндсэн хөрөнгө данс тайлант онд худалдан авсан 4,392.7 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 74,793.5 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн, хуримтлагдсан элэгдэл 341,064.7 мянган төгрөг, 9,980.0 мянган төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассан зэргээс шалтгаалж 265,952.6 мянган төгрөгөөр буурсан.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,279,508.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3,279,508.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 231,884.9 мянган төгрөгөөр бууруулж 3,047,624.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 54,293.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 3,101,917.2 мянган төгрөгөөр баталсан.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,101,917.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 2,378,672.3 мянган

төгрөгийг улсын төсвөөс, 723,245.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,378,672.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 175,487.5 мянга, нийт 2,554,159.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,466,556.2 мянган төгрөгийг зарцуулж 87,603.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, үүнээс 1,052.1 мянган төгрөгийг авлагаар тайлагнасан байна. Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого 547,757.5 мянган төгрөгөөр төлөвлөсөн хэмжээнээс буурсан нь сувилалын үйл ажиллагаа зогссоноос шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,466,556.2 мянган төгрөг буюу 79.5 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 386,436.1 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардлыг 214,404.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсанаас голлон шалтгаалсан байна.

*Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71902	Нийгмийн халамж	3,101,917.3	2,466,556.2	635,361.1	79.5
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны урсгал зардал	2,300,662.6	1,936,219.0	364,443.6	84.2
1.2	83115	Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр	174,447.7	175,487.5	(1,039.8)	100.6
1.3	80102	Туслах үйл ажиллагаа	548,797.3	276,897.6	271,899.7	50.5
1.4	80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	33,366.9	33,366.9	0	100.0
1.5	80802	Тэтгэмж, урамшуулал	44,642.8	44,585.2	57.6	99.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Өмнөх онд татан төвлөрүүлсэн авлага 6,550.9 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 5,498.9 мянган төгрөгийг зарцуулж 1,052.0 мянган төгрөгийг төвлөрүүлж авлагаар тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Асуудлыг онцолсон хэсэг:

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад

баримтлах ерөнхий чиглэл"-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгаанд Электра суудлын машин, микро автобусыг 2021 онд бүрэн ашиглаагүй, төсвийн тодотголоор санхүүжилтийн орлого 10 хувь хасагдсан тул зорилтот түвшин биелээгүй байна.

#### Бусад асуудлын хэсэг:

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 79.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Ковид-19 цар тахлын нөхцөл байдал 150 гаруй үйлчлүүлэгчид хүндээр нөлөөлж ихэнх үйлчлүүлэгчид өвчилсөн боловч хөнгөлөлттэй эмээр бүрэн үйлчлүүлж чадаагүй, байгууллагаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 153,461.2 мянган төгрөгийн эм хэрэглэж өмнөх оноос 27,683.2 мянган төгрөгөөр илүү эм зарцуулсныг тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал гэж үзсэн болно.

Хөдөлмөр нийгэм хамгааллын сайдын “Төрөлжсөн асрамж болгох тухай” 2021 оны А/53 тоот тушаалаар Ахмад настны үндэсний төвийн ахмадын нөхөн сэргээх сувиллын үйл ажиллагааг зогсоож “асрамж-1”, “асрамж-2” гэж зохион байгуулалтын өөрчлөлт хийсэн байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Ахмад настны үндэсний төв нь 128 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 103 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 17 мэдээллийг хугацаа хоцроож, 8 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэсэн заалттай нийцээгүй, эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргасан ерөнхий нягтлан бодогч С.Нэргүйд сахилгын шийтгэл оногдуулах албан шаардлага өгөв.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайлант оны худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтын үнэлгээ хийсэн тендерийн үнэлгээний хорооны гишүүдийн А-3 сертификат байхгүй, үнэлгээний хорооны

гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг болон ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх мэдэгдэл байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн ТБОНӨХБАҮХАТ хуулийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 1,855,995.2 мянган төгрөгийн 8 зөрчил илэрснээс аудитын явцад 4 зөрчлийг залруулж, 1,426,569.4 мянган төгрөгийн шилэн дансны мэдээллийг нөхөн шивсэн байна.

Өмнөх жилийн эцсийн аудитаар тогтоосон төлбөрийн актын биелэлт 46.9 хувьтай, 430,852.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага биелээгүй, 7,040.0 мянган төгрөгийн 4 зөвлөмжийн хэрэгжилт 25 хувьтай байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт:

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	9,843.5	0.53	5,218.7	0.47	(4,624.8)	46.9
Албан шаардлага	2	430,852.4	0	0	2	(430,852.4)	0
Зөвлөмж	4	7,040.0	1	7,040.0	3	0	25.0
Нийт дүн	7	447,735.9		12,258.7		(435,477.2)	18.0

Хэрэгжүүлээгүй 1 зөвлөмжид албан шаардлага өгч, төлбөрийн актын үлдэгдэл 4,627.8 мянган төгрөг, 430,852.4 мянган төгрөгийн болон шилэн дансны тухай хуулийн заалтыг хэрэгжүүлээгүй зөрчлийг дахин давтан гаргасан зөрчилд холбогдох албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Үйлчлүүлэгчдийг зуны улиралд байрлуулах дуусаагүй барилгын гүйцэтгэлийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 185,787.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 169,650.5 мянган төгрөгийн 5 алдааг залруулж, 1,119.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 15,018.3 мянган төгрөгийн 3 алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 16,137.4 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 12,644.2 мянган төгрөгөөр бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдаа санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

- Туслах аж ахуйн малаас ажилчдад олгосон, нядалж худалдсан 23,344.0 мянган төгрөгийн мал, махны төлбөрийг бараа материал, жижиг мөнгөн сан (касс), төрийн сангийн харилцах дансаар дамжуулахгүйгээр бэлэн мөнгөөр шууд барилгын материал худалдан авсан, малын орлогыг Санхүүгийн үр дүнгийн

тайланд туслах үйл ажиллагааны орлогоор бүртгээгүй зөрчлийг аудитын явцад залруулж бүртгэсэн;

- Үйлчлүүлэгчдийг зуны улиралд байрлуулах зорилгоор барьж байгаа модон байшингийн өртөг 14,972.0 мянган төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайланд зардлаар тайлагнасныг аудитын явцад залруулж дуусаагүй барилгад бүртгэсэн;
- Санхүүгийн тайлангийн тодруулгад малын нас дэвшилт, шинэ төлийн 30,120.0 мянган төгрөгийн орлогыг хандиваар, хандиваар авсан үндсэн хөрөнгийн 7,060.0 мянган төгрөгийн орлогыг бусад эх үүсвэрээс гэж алдаатай тодруулсныг залруулсан;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлагнасан нэмэлт санхүүжилтийн 6,550.9 мянган төгрөгийг залруулж нэмэлт санхүүжилтийн тайлан гаргуулсан;
- Улсын төсвийн санхүүжилтаас төвлөрүүлсэн 86,551.6 мянга, нэмэлт санхүүжилтаас төвлөрүүлсэн 1,052.0 мянган төгрөгийг төсвийн гүйцэтгэл, нэмэлт санхүүжилтийн тайланд тус тус залруулсан.

## 4.2 Төлбөрийн акт

Нийт 9 ажилтны цалингаас 983.8 мянган төгрөгийн ХХОАТ суутгаагүй, гэрээт 3 ажилтанд олгосон цалингаас 135.3 мянган төгрөгийн ХХОАТ-ын чөлөөлөлтийг давхардуулсан нийт 1,119.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, ХХОАТ-ын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 “цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулна”, 23 дугаар зүйлийн 23.1.Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-т заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

## 4.3 Албан шаардлага

1. Туслах үйл ажиллагааны 23,344.0 мянган төгрөгийн орлогыг Төрийн сангийн харилцах дансанд төвлөрүүлээгүй, төсвийн гүйцэтгэлийн тайланд орлого, дотоод эх үүсвэрээр хөрөнгийн зардлаар тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, 8 дугаар зүйлийн 8.2 “Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана”, 14 дүгээр зүйлийн 14.4. “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.1 “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.4 “аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр”, 14.4.5 “бүх орлого”, 14.4.6” “бүх зардал”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7 “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

2. Хүнсний материалын худалдан авалт, зарцуулалтын нийт 582,765,100.00 төгрөгийн гүйлгээг дансанд тухай бүр бүртгээгүй, сард нэг удаа бөөн дүнгээр нь бүртгэснээс нөөц болон орцын норм, өдрийн үлдэгдлийг тодорхойлох, хянах боломжгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, 8.2 “Энэ хуулийн 4.4 заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3 нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана”, 14 дүгээр зүйлийн 14.4 Нягтлан бодох

бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1.аж ахуйн бүх ажил, гүйлгээ; 14.4.4 аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр; 14.4.5 бүх орлого; 14.4.6 бүх зардал; Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7 “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагааны онцлогт тохируулан сайжруулах, дансны бичилтүүдийг бүрэн тусгах тухай өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.”Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

#### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Эм, эмнэлэгийн хэрэгсэлийн хяналттай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 дугаартай тушаалаар баталсан СТ-27 маягт хөтлөөгүй, эмийн зарлагын баримтыг сараар нэгтгэн бичиж байгаагаас зарцуулсан эм, тариаг өвчтөний түүх (стор)-тэй тулгаж хянах боломжгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

*СТ-27 маягтыг хөтөлж, эмийн зарлагын баримтыг өдөр бүр үйлдэж, эм, тариа, эмнэлэгийн материалын зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулах*

##### **2. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт

*Худалдан авалтын 13 ширхэг, 15,018.3 мянган төгрөгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулаагүй, мөнгөн хөрөнгийн данснаас шууд зардалд бичилт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.3 “бүх өр төлбөр” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна*

Өгсөн зөвлөмж

*Бараа материалын гүйлгээ бүрийг тухай бүр санхүүгийн программд бүртгэж байх, худалдан авалт бүрийг тооцооны дансаар дамжуулан бүртгэж байх, дотоод хяналтыг сайжруулах*

##### **3. Дотоод хяналт, санхүүгийн тайлантай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

*Дотоод хяналтын ажлын төлөвлөгөө, хийсэн ажлын үр дүн, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын хяналт хангалтгүйгээс санхүүгийн тайланг алдаатай*



*тайлагнах, хугацаа хоцроож аудитын байгууллагад ирүүлж байгаа зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 5.1."Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 1.4. "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1."төсвийн шууд захирагч ...жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж"... гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна*

Өгсөн зөвлөмж

*Дотоод хяналтын ажлын төлөвлөгөөг үр дүнтэй байхаар төлөвлөж батлах, төлөвлөгөөний дагуу хийсэн ажлын үр дүнг удирлагын зүгээс үнэлж, баталгаажуулж байх, нягтлан бодогчдыг чадавхжуулах, санхүүгийн тайланг хуулийн хугацаанд, үнэн зөв тайлагнаж байх*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллага болон аудитын хуулийн этгээдэд 2022 оны 09 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаарлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
							тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																
1	АНУ Төв	АХГ-2022/230/НА-СТА-ТШЗ	Үйлчлүүлэгчдийг зуны улиралд байрлуулах зорилгоор барьж байгаа модон байшингийн өртөг 14,972.0 мянган төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайланд зардлаар тайлагнасныг аудитын явцад залруулж дуусаагүй барилгад бүртгэсэн.	Зөрчлийг давтахгүй байх	1	14,972.0	1	14,972.0								
2	АНУ Төв	АХГ-2022/230/НА-СТА-ТШЗ	Санхүүгийн тайлангийн тодруулгад малын нас дэвшилт, шинэ төлийн 30,120.0 мянган төгрөгийн орлогыг бусад эх үүсвэрээс гэж алдаатай тодруулсныг залруулсан.	Зөрчлийг давтахгүй байх	1	30,120.0	1	30,120.0								
3	АНУ Төв	АХГ-2022/230/НА-СТА-ТШЗ	Санхүүгийн тайлангийн тодруулгад 7,060.0 мянган төгрөгийн орлогыг бусад эх үүсвэрээс гэж алдаатай тодруулсныг залруулсан.	Зөрчлийг давтахгүй байх	1	7,060.0	1	7,060.0								
4	АНУ Төв	АХГ-2022/230/НА-СТА-ТШЗ	Туслах аж ахуйн малаас ажилчдад олгосон, нядалж худалдсан 23,344.0 мянган төгрөгийн мал, махны төлбөрийг бараа материал, жижиг мөнгөн сан (касс), төрийн сангийн харилцах дансаар дамжуулахгүйгээр бэлэн мөнгөөр шууд барилгын материал худалдан авсан, малын орлогыг Санхүүгийн үр дүнгийн тайланд туслах үйл ажиллагааны орлогоор бүртгээгүй зөрчлийг аудитын явцад залруулж санхүүгийн үр дүнгийн тайланд туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн	Зөрчлийг давтахгүй байх	1	23,344.0	1	23,344.0								
5	АНУ Төв	АХГ-2022/230/НА-СТА-ТШЗ	9 ажилтны 1 дүгээр сарын цалингаас 983.8 мянган төгрөгийн ХХОАТ суутгаагүй зөрчил гаргасан	Хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтахгүй	1	983.8			1	983.8						

Ахмад настны үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн аудитын тайлан

				байх												
6	АНУ Төв	АХГ-2022/230/НА-СТА-ТШЗ	Гэрээт 3 ажилтанд олгосон цалингаас 135.3 мянган төгрөгийн ХХОАТ-ын чөлөөлөлтийг давхар хийсэн нийт 1,119.1 мянган төгрөгийн зөрчил гаргасан	Хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтахгүй байх	1	135.3				1	135.3					
7	АНУ Төв	АХГ-2022/230/НА-СТА-ТШЗ	Туслах аж ахуйн 23,344.0 мянган төгрөгийн орлогыг төрийн сангийн харилцах дансанд төвлөрүүлээгүй, холбогдох зардлын зүйл ангид зардал хуваарилуулан зарцуулаагүй, төсвийн гүйцэтгэлийн тайланд орлого зардлыг тайлагнаагүй	Стандарт, хуулийн заалтыг хэрэгжүүлж тайланг үнэн зөв гаргаж, зөрчлийг давтахгүй байх	1	-				1	-					
8	АНУ Төв	АХГ-2022/230/НА-СТА-ТШЗ	Худалдан авалтын 13 ширхэг, 15,018.3 мянган төгрөгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулаагүй, мөнгөн хөрөнгийн данснаас шууд зардалд бичилт хийсэн	Стандарт, хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтахгүй байх	1	15,018.3									1	15,018.3
9	АНУ Төв	АХГ-2022/230/НА-СТА-ТШЗ	Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 дугаартай тушаалаар баталсан СТ-27 маягт хөтлөөгүй, эмийн зарлагын баримтыг сараар нэгтгэн бичиж байгаагаас зарцуулсан эм, тариаг өвчтөний түүх (стор)-тэй тулгаж хянах боломжгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	Зөрчлийг давтахгүй байх	1										1	-
10	АНУ Төв	АХГ-2022/230/НА-СТА-ТШЗ	Дотоод хяналтын ажлын төлөвлөгөө, хийсэн ажлын үр дүн, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын хяналт хангалтгүйгээс санхүүгийн тайланг алдаатай тайлагнах, хугацаа хоцроож аудитын байгууллагад ирүүлж байгаа зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 5.1."Аж ахуйн	Зөрчлийг давтахгүй байх	1										1	-

**Ахмад настны үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

			нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 1.4. "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1."төсвийн шууд захирагч ...жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж"..." гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.													
11	АНУ Төв	АХГ-2022/230/НА-СТА-ТШЗ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагааны онцлогт тохируулан сайжруулах, дансны бичилтүүдийг бүрэн тусгах тухай өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	Зөрчлийг давтахгүй байх	1					1	-					
12	АНУ Төв	АХГ-2022/230/НА-СТА-ТШЗ	Хүнсний материалын худалдан авалт, зарцуулалтын нийт 582,765,100.00 төгрөгийн гүйлгээг дансанд тухай бүр бүртгээгүй, сард нэг удаа бөөн дүнгээр нь бүртгэснээс нөөц болон орцын норм, өдрийн үлдэгдлийг тодорхойлох, хянах боломжгүй байна.	Зөрчлийг давтахгүй байх	1					1	-					
Дүн					12	91,633.4	4	75,496.0	2	1,119.1	3	-	-	-	3	15,018.3
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																
1	АНУ Төв	АХГ-2022/230/НА-СТА-ТШЗ	2021 оны батлагдсан төсөв, худалдан авалтын тайланг ил тод байршуулаагүй, 1,464,046.1 мянган төгрөгийн санхүүжилтийн 17 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	Аудитын зөвлөмж, шилэн дансны хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах	1	1,464,046.1				1	1,464,046.1	1	1,464,046.1			
Дүн					1	1,464,046.1	-	-	-	-	1	1,464,046.1	1	1,464,046.1	-	-
Нийт дүн					13	1,555,679.5	4	75,496.0	2	1,119.1	4	1,464,046.1	1	1,464,046.1	3	15,018.3



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25

№ 61/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/030/НА-СТА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Ахмад настны үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ахмад настны үндэсний төв нь нийт 9 ажилтны цалингаас 983,798.00 төгрөгийн ХХОАТ суутгаагүй, гэрээт 3 ажилтанд олгосон цалингаас 135,300.00 төгрөгийн ХХОАТ-ын чөлөөлөлтийг давхардуулсан нийт 1,119,098.00 төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", ХХОАТ-ын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 "цалин, хөдөлмөрийн хөнгөлөлт, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулна", 23 дугаар зүйлийн 23.1. Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, Санхүүгийн тайлангийн "үнэн зөв" батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Ажилтнуудаас суутгаагүй, давхар хөнгөлсөн нийт 1,119,098.00 /нэг сая нэг зуун арван есөн мянга ерэн найм/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ахмад настны үндэсний төвийн дарга Л.Эрдэнэхүү, Ерөнхий нягтлан бодогч С.Нэргүй нарт хариуцуулах.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
БЭСТ ФОРТУНА АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ

Ж.ОЮУНЦЭЦЭГ

001090189



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 316/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/230/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Ахмад настны үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хүнсний материалын худалдан авалт, зарцуулалтын нийт 582,765,100.00 төгрөгийн гүйлгээг дансанд тухай бүр бүртгээгүй, сард нэг удаа бөөн дүнгээр нь бүртгэснээс нөөц болон орцын норм, өдрийн үлдэгдлийг тодорхойлох, хянах боломжгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8.2 "Энэ хуулийн 4.4 заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3 нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана", 14 дүгээр зүйлийн 14.4 "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1."аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.4 "аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр", 14.4.5 "бүх орлого", 14.4.6 "бүх зардал", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7 "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтыг сайжруулах, бараа материалыг анхан шатны баримтад үндэслэн тухай бүр данс бүртгэлд тусгаж байх, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ахмад настны үндэсний төвийн дарга Л.Эрдэнэхүү, ерөнхий нягтлан бодогч С.Нэргүй нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
БЭСТ ФОРТУНА АУДИТ ХХК-ийн  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ  
Ж.ОЮУНЦЭЦЭГ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-704230

\\10.10.10.20\Bichig\_Khureg\Alban\_Shaardlaga\2022\0225\_Auditin\_2\_Gaar-317.Docs

0010800921





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 317/А0150058  
АХГ-2022/230/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Ахмад настны үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагааны онцлогт тохируулан сайжруулах, дансны бичилтүүдийг бүрэн тусгах тухай өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2 "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах", 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагааны онцлогт тохируулан шинэчлэн сайжруулж, баталж мөрдөх, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ахмад настны үндэсний төвийн дарга Л.Эрдэнэхүү, ерөнхий нягтлан бодогч С.Нэргүй нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
БЭСТ ФОРТУНА АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ

Ж.ӨЮУНЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

\\0.10.10.26\Bichig\_Khureg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gnar-316.Docx

00108C0919



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 318/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/230/НА-СТА-ТШЗ

Сахилгын шийтгэл оногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Ахмад настны үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 3,671,732,180.00 төгрөгийн ажил гүйлгээний 128 мэдээллийг ил тод байршуулахаас 17 мэдээллийг хугацаа хоцроож, 8 мэдээллийг байршуулаагүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн данстай холбогдох зөрчилд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, ... бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.2 заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:


1. Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй, өмнөх оны аудитаар өгсөн 2 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй ерөнхий нягтлан бодогч С.Нэргүйд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ахмад настны үндэсний төвийн дарга Л.Эрдэнэхүүд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН,  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
БЭСТ ФОРТУНА АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ

Ж.ОЮУНЦЭЦЭГ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

\\UJ.10.10.20\Bichig\_Khorog\Alban\_Shaardlaga\2022\0225\_Auditin\_2\_Gazar-315.Docx

00108C0917





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 319 /А0150058  
АХГ-2022/230/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Ахмад настны үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Туслах үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн харилцах дансанд төвлөрүүлээгүй,
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд орлого, дотоод эх үүсвэрээр хөрөнгийн зардалд тайлагнаагүй,
- Санхүүгийн үр дүнгийн тайланд орлогоор тайлагнаагүй,
- 23,344,000 төгрөгийн бэлэн мөнгөөр бараа материал худалдан авч дуусаагүй барилгад зарцуулсан боловч шууд зардалд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2 "Энэ хуулийн 4.4 заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3 нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана", 14 дүгээр зүйлийн 14.4. "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1. "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.4. "аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр", 14.4.5. "бүх орлого", 14.4.6. "бүх зардал", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7 "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, даатан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодох бүртгэлд бүх орлого, зардлыг тайлагнах, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг даатан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ахмад настны үндэсний төвийн дарга Л.Эрдэнэхүү, ерөнхий нягтлан бодогч С.Нэргүй нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЕРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
БЭСТ ФОРТУНА АУДИТ ХХ-ийн  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ

Ж.ОЮУНЦЭЦЭГ

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-204230

1170.10.10.2019chig\_Akhreguliban Shaardlaga(2022)0225 Auditin 2 Gzar-314.Docx

00108C0915





